

## Монголын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа

МУИС, ЭЗС-ийн статистикийн тэнхим,  
дадлагажигч багш, магистр, Б.Мягмарсүрэн

2001 ий 6 сарын 14-н өдөр Олон Улсын Эдийн Засаг-статистикийн 57-р тогтоолоор "Монгол Улсын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

Үндэсний статистикийн хорооноос ажлын үр дүнд үзүүлсэн судалгаагаар 2001 оны 6 сарын 14-н өдөр Олон Улсын Эдийн Засаг-статистикийн 57-р тогтоолоор "Монгол Улсын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

Орлогын судалгаагаар ажлын үр дүнд үзүүлсэн судалгаагаар 2001 оны 6 сарын 14-н өдөр Олон Улсын Эдийн Засаг-статистикийн 57-р тогтоолоор "Монгол Улсын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

Ажлын үр дүнд үзүүлсэн судалгаагаар 2001 оны 6 сарын 14-н өдөр Олон Улсын Эдийн Засаг-статистикийн 57-р тогтоолоор "Монгол Улсын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

Ажлын үр дүнд үзүүлсэн судалгаагаар 2001 оны 6 сарын 14-н өдөр Олон Улсын Эдийн Засаг-статистикийн 57-р тогтоолоор "Монгол Улсын бүс нутгуудын эдийн засаг-статистикийн судалгаа"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

### Удиртгал

### Сэдвийн судлагдах шаардлага

2001 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Улсын Их Хурлын 57-р тогтоолоор "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүний эдийн нөөц, оюуны чадварыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр

хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задлаж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутгийн хоорондын тэгш бус тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино” гэж заажээ.

Иймээс бүс нутгуудийн эдийн засгийг харьцуулан судалж тэдгээрийн ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг илрүүлэн судлах шаардлага урган гарч байна.

### **Судалгааны зорилго**

Бүсчлэлийн дүнд тэдгээрийн эдийн засгийн ялгаатай байдал, хөгжлийн түвшин ойртох хандлага илэрч буй эсэх, бүсүүдийн эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох, эдийн засгийн үзүүлэлтүүдээрээ ижил, төсөөтэй аймгуудыг тогтоох, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн тусламжтайгаар тэдгээрийн эрэмбэлэх зорилтуудыг тавьсан юм.

### **Сэдвийн судлагдсан байдал**

Манай орны эдийн засгийн бүсчлэлийн асуудал нь ХХ зууны эхэн үеэс “худалдааны бүс” хэмээх ойлголтоос анхлан тавигдсан гэж үздэг байна.

Монгол улсын нутаг дэвсгэр-эдийн засгийн бүсчлэлийн онол арга зүйн асуудалд Шинжлэх ухааны академи (ШУА), Улсын төлөвлөгөөний комисс, Эдийн засгийн судалгаа шинжилгээний төв байгууллагын эрдэмтэн, ажилчид, ШУА-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ч.Сэрээтэр, Монгол улсын эдийн засгийн газар зүйн ухааны нэрт эрдэмтэн, Академич Б.Гунгаадаш, Академич Б.Ширэндив, Ерөнхий сайд асан, нэрт эдийн засагч Д.Содном, Доктор Б.Баянтөр, Д.Батцэнгэл, Бадамдорж, доктор Л.Энхтайван, доктор Л.Цэдэндамба, Б.Чадраа зэрэг эрдэмтэд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Харин Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад хийгдсэн бүслэл нь хэд хэдэн зарчимд тулгуурлан, чанарын судалгааны үр дүнд хийгдсэн.

Мөн 2003 онд ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс явуулсан “Монгол Улсын Хөгжлийн Судалгаа (Бүс нутгийн хөгжлийн нөөц, түүнийг зохистой ашиглах арга зам)”-нд бүс нутгуудыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны тал бүрээс нь авч үзэн, тэдгээрийн нөөц боломж, ашиглалтийг судлан үзсэн томоохон судалгаа хийгдсэн байна.

### **Судалгааны арга зүй, мэдээллийн эх үүсвэр**

Энэхүү судалгаандаа мэдээллийн хоёрдогч эх үүсвэр болох Үндэсний статистикийн газраас (ҮСГ) тооцсон мэдээллийг ашигласан.

Эдийн засгийн онол, ойлголтуудад тулгуурлан статистик, эконометрикийн харьцуулалт, олон хэмжээст бүлэглэлтийн аргуудыг MS-Excel, SPSS 11.5, Olymp, Statistica 6.0, E-VIEWS 3.01 багц програмуудыг ашиглан боловсруулалт хийв.

Мөн Монгол улсын эдийн засгийн баруун, хангайн, зүүн, төвийн бүсүүдийг судалгааны объект болгон авч, тэдгээр бүсүүдэд хамаарах аймгуудыг нь судалгааны нэгж болгон авч үзлээ.

Бүс нутгуудыг эдийн засгийн талаас нь судалж харьцуулалт хийн бүсүүдийн эдийн засгийн хөгжлийг загварчлан, аймгуудыг олон хэмжээст ангиллын аргаар бүлэглэн, тэдгээрийг тодорхой үзүүлэлтүүдээр эрэмбэлж байгаа нь судалгааны ажлын онцлог юм.

## **Монголын бүс нутгууд, тэдгээрийн төлөв байдал, харьцуулалт**

### **Ойлголт ба тодорхойлолт**

Монгол Улсын Их Хурал 2001 оны 57 дугаар тогтоолоор "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг (БХҮБ) баталсан. Бүс нутгийн ийм цогцолборуудыг байгуулах нийгмийн зорилго буюу хөгжлийн гол шалгуур нь аймаг, орон нутгийн хүн амын нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангах явдал билээ.

БХҮБ нь Монголын нийгмийн амьдралын бүх хүрээний асуудлыг хамарсан, хөдөө, орон нутгийн төдийгүй, улс орны стратегийн хөгжлийн "цогц үзэл баримтлал" мөн бөгөөд хэд хэдэн Засгийн газрыг дамжин, иргэний нийгмийн бүх талуудын оролцоо, олон улсын дэмжлэг шаардан хэрэгжих "Үндэсний хэмжээний бодлого" гэдэг нь харагдаж байна. БХҮБ нь Монголын нийгмийн болон зах зээлийн харилцааг бүс нутгийн хандлагаар гүнзгийрүүлж, аймаг, сум, хот, тосгон, аж ахуйн салбар бүр, цаашилбал улс гүрнүүд "харилцан хамаарал"-тай, "харилцан дэмжлэг"-тэй аж төрөх орчинг бүрдүүлэх өнөө ба ирээдүйн шаардлагаас урган гарч байгаа болно.

**"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"**-д эдийн засгийн бүсчлэл гэж хөгжлийн зорилгод нийцүүлэн Монгол улсын нутаг дэвсгэрийг дотоод зах зээл хөгжих, гадаад зах зээлтэй холбох газар зүйн байрлалын боломж, аймаг, сумын аж ахуй, соёлын уламжлалт харилцаа холбоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтын нийтлэг байдал, байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээгээр бүрэн зохистой хоршин ашиглах боломж зэргээр нь эдийн засгийн бүсүүд болгон зохион байгуулж, эдийн засаг дэд бүтцийн хөгжлийг уг бүсүүдээр зохицуулах үйл ажиллагаа, эдийн засгийн бүс гэж нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийн төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай

бодлого явуулах шаардлагыг харгалзан тогтоосон нутаг дэсгэрийн зааг хүрээг хэлнэ гэж заажээ. Харин эдийн засгийн бүсүүдийн хуваарийг тогтоохдоо:

- аймаг, орон нутгын хүн амын аж байдлын түвшний ялгаа, түүнийг жигдрүүлэх асуудлыг тухайн бүсын хүрээнд шийдвэрлэх дотоод, гадаад зах зээл болон төрийн зохицуулалтын боломж, газар, түүний баялгийг хамгаалах, ашиглах эзэмших зохимжит чиг хандлага зэргийг бодолцсон нийгэм, экологийн хүчин зүйлсийн;
- аймаг, сум аж ахуйн нэгж байгууллага хоорондын хоршил холбоонд түшиглэн тухайн бүсын хүн амын хэрэгцээг хангах, байгаль орчныг хамгаалах шаардалагад зохицсон үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой бүтэц бүхий дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай нэг буюу хэд хэдэн бүтээгдэхүүнээр улсын хэмжээнд төрөлжсөн, бүс нутгын аж ахуйн бие даасан цогцолборууд бүрдэх ирээдүйн төлвийг баримжаалсан эдийн засаг, эдийн засгийн хүчин зүйлсийн;
- хот, тосгоны зэрэглэл тогтоон, тэдгээрийн дотроос хөдөөгийн хүн амын амьдралыг бүс нутгийн дотоод гадаад орчинтой дэд бүтцийн сүлжээгээр зохистой холбон зохион байгуулах боломжтой, ирээдүй сайтай байршсан хот, тосгоныг бүсийн, сум дундын буюу бүлэг суурингийн төв болгон сонгох хөгжүүлэх нөхцлийг харгалзсан дэд бүтэц, хот байгуулалтын хүчин зүйлсийн аргуудыг хослон хэрэглэнэ гэжээ.

Дээрх хүчин зүйлсүүдэд үндэслэн Монгол улс эдийн засгийн 4 бүс, түүний төвүүдтэй байна гэж үзсэн:

1. *Баруун бүсэд*: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгууд, *бүсийн тулгуур төв хот*: Ховд хот, Улиастай хот
2. *Хангайн бүсэд*: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, *бүсийн тулгуур төв хот*: Хар-хорин хот, Эрдэнэт хот
3. *Төвийн бүсэд*: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, *бүсийн тулгуур төв хот*: Зуун мод хот, Дархан хот
4. *Зүүн бүсэд*: Дорнод, Сүхбаатар, Хэнтий, *бүсийн тулгуур төв хот*: Чойбалсан хот, Өндөрхаан хот
5. *Улаанбаатар*: нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.

Бүс нутгуудийн эдийн засгийн харьцуулсан шинжилгээг хийхдээ эдийн засгийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар нь авч харьцуулан ерөнхий дүр зургийг гаргаж ирэхийг зорилоо.

Сонгосон үзүүлэлтүүдийг бүс нутгуудаар авч үзье. 1999 оноос эхлэн Үндэсний статистикийн газар эдийн засгийн гол үзүүлэлт болох ДНБ-ийг аймгаар тооцож эхэлсэн учир энэхүү ажилдаа 1999-2003 оны мэдээллийг ашиглан судалсан. Иймээс мэдээллийн хязгаарлагдмал байдлын улмаас түүнд тохируулан шинжилгээ хийхийг зорьсон юм.

## **Бүсүүдийн төлөв байдал**

### **А. Баруун бүс**

Монгол улсын томоохон нутаг дэвсгэр бүхий Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 5 аймаг нийт 93 сумтай, 415256 км.кв нутаг дэвсгэртэй бөгөөд монгол орны нийт нутаг дэвсгэрийн 26.52хувийг эзэлж оршдог.

Тус бүс нь (2003 он байдлаар) 414.5 мянган хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 175.0 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 95.3 хувь. Нийт улсын малын 29.14хувь буюу 7410.8 мянган толгой малтай. Ерөнхий боловсролын 153 сургууль, 134 цэцэрлэгтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж 2462.

Мөн улсын чанартай авто замын 4008 км буюу нийт дүнгийн 36 хувь нь оршдог ба төмөр замын сүлжээ байхгүй.

2003 он байдлаар баруун бүсийн ДНБ (ДНБ) 111622.1 сая төгрөг буюу нийт улсын ДНБ-ний 7.6 хувийг үйлдвэрлэжээ. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 30 хувиар бага байв.

### **Б. Хангайн бүс**

Монгол улсын дунд зэргийн нутаг дэвсгэр бүхий Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Эрдэнэт хотын харъяалсан Орхон аймгийн нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 7 аймаг нийт 95 сумтай, 47355.5 км.га нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 24.59 хувийг эзэлж оршдог.

Тус бүс нь (2003 он байдлаар) 442.3 мянган хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 178.7 мянган хүн, ажиллах хүчний оролцооны түвшин 97.6 хувь. Нийт улсын малын 22.51 хувь буюу 5723.7 мянган толгой малтай. Ерөнхий боловсролын 159 сургууль, 158 цэцэрлэгтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж 3041 байна.

Улсын чанартай авто замын 2598 км буюу нийт дүнгийн 23.4 хувь, төмөр замын 41 км буюу 2.2 хувь, байнгын ашиглалттай усан замын 41 хувь нь тус бүсэд оршиж байна.

Хангайн бүсийн ДНБ (2003 онд) 259493.2 сая төгрөг буюу нийт улсын ДНБ-ний 17.8 хувийг үйлдвэрлэсэн. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 5 хувиар бага байна.

### **В. Төвийн бүс**

Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудын нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 7 аймаг нийт 99 сумтай,

38502.5 км.га нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 24.59 хувийг эзэлж оршдог.

Тус бүс нь (2003 он байдлаар) 551.9 мянган хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 237.3 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 94.7 хувь байна. Нийт улсын малын 31.98 хувь буюу 8131.7 мянган толгой малтай. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж 3536 байна.

Улсын чанартай авто замын 2418 км буюу нийт дүнгийн 21.7 хувь, төмөр замын 1413.7 км буюу 78.0 хувь нь тус бүсэд оршиж байна.

Төвийн бүсийн ДНБ (2003 онд) 161227.1 сая төгрөг буюу нийт улсын ДНБ-ний 11.0 хувийг үйлдвэрлэсэн. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 6.4 хувиар бага байна.

### **Г. Зүүн бүс**

Монгол улсын дунд зэргийн нутаг дэвсгэр бүхий Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 3 аймаг нийт 44 сумтай, 28620.9 мян.га нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 18.28 хувийг эзэлж оршдог.

Тус бүс нь (2003 он байдлаар) 201.9 мянган хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 72.9 мянган хүн, ажиллах хүчний оролцооны түвшин 69.6 хувь байв. Нийт улсын малын 15.41 хувь буюу 3918.2 мянган толгой малтай, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж 1201 байна.

Улсын чанартай авто замын 1984 км буюу нийт дүнгийн 17.2 хувь, төмөр замын 246 км буюу 2.2 хувь, байнгын ашиглалттай усан замын 13.6 хувь нь тус бүсэд оршиж байна.

Зүүн бүсийн ДНБ (2003 онд) 80176.8 сая төгрөг буюу нийт улсын ДНБ-ний 5.5 хувийг үйлдвэрлэсэн. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 12.4 хувиар бага байна.

### **Д. Улаанбаатарын бүс**

Улаанбаатарын бүс нийт 9 дүүрэгтэй, 121 хороотой бөгөөд 470.4 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг.

Тус бүс нь (2003 он байдлаар) 893.4 мянган хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 295.9 мянган хүн, ажиллах хүчний оролцооны түвшин 98.1 хувь байв. Нийт улсын малын 0.96 хувь буюу 243.3 мянган толгой малтай, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж 16312 байна.

Улсын чанартай авто замын 113 км буюу нийт дүнгийн 1.0 хувь, төмөр замын 112 км буюу 6.2 хувь нь тус бүсэд оршиж байна.

Улаанбаатарын бүсийн ДНБ (2003 онд) 848650.0 сая төгрөг буюу нийт улсын ДНБ-ний 58.1 хувийг үйлдвэрлэсэн. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 4.2 хувиар их байна.


## Бүсүүдийн эдийн засгийн харьцуулалт

### Бүс нутгуудийн хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл


Юуны түрүүнд хөгжлийн гол объект болох хүн амын үзүүлэлтүүдээр харьцуулан үзье. 2003 оны байдлаар нийт хүн амын 16.6 хувь баруун бүсэд, 22.0 хувь хангайн бүсэд, 17.7 хувь төвийн бүсэд, 8.1 хувь зүүн бүсэд, 35.7 хувь Улаанбаатарын бүсэд суурин амьдарч байна. Бүс хоорондын хүн амын тархалтын бүтцэд огцом өөрчлөлт ороогүй боловч 2003 оныг 1999 онтой харьцуулахад Улаанбаатарын бүсийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь 3.7 пунктээр өссөн нь баруун бүсийн 1.2 пункт, хангайн бүсийн 1.0 пункт, төвийн бүсийн 1 пункт, зүүн бүсийн 0.4 пунтийн бууралтуудаар тайлбарлаж болох юм ( $1.2+1.0+1.0+0.4=3.6$  пункт). Энэ нь бүсүүдийн шилжих хөдөлгөөн нь Улаанбаатарын бүс рүү чиглэсэн болохыг илэрхийлж байна. Мөн бүс доторх хүн амын тархалтын бүтэц тогтвортой байгаа ба нэг бүсийн аймгуудад хүн ам жигд тархсан байна.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам болон ажиллагсдыг тархалтаар нь авч үзвэл нийт эдийн засгийн идэвхитэй хүн амын 18.2 хувь баруун бүсэд, 24.7 хувь нь хангайн бүсэд, 18.6 хувь төвийн бүсэд, 7.6 хувь зүүн бүсэд, 30.8 хувь Улаанбаатарын бүсэд суурин амьдарч байна.

Зураг 1. Эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагсдын хувийн жин, бүсүүдээр



Зураг 2. Ажилгүйдлийн түвшин бүсүүдээр, дүнд эзлэх хувиар



Зураг 2-оос харвал, 2003 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн 37.8 хувь буюу хамгийн их нь хангайн бүсэд, 24.6 хувь баруун бүсэд, 17.1 хувь Улаанбаатарын бүсэд, 12.9 хувь төвийн бүсэд, 7.5 хувь буюу хамгийн бага хэсэг нь зүүн бүсэд амьдарч байна.

Тэдгээрийн динамикийг харвал, 1999-2003 онуудад зүүн, баруун болон төвийн бүсүүдийн ажилгүйдлийн түвшин буурах, хангайн болон Улаанбаатарын бүсүүдэд өсөх хандлагатай байна.

Хүн ам, шилжих хөдөлгөөний судалгаануудаас харахад, хүн амын шилжих хөдөлгөөний гол шалтгаан нь шилжигчид аж амьдралаа дээшлүүлэх зорилгоор ажлын байр хайн, гэр бүлээрээ шилждэг ба 1995-2000 оны хугацаанд нийт шилжигчдын 65 хувь нь Улаанбаатарт шилжин иржээ. Мөн Төвийн бүсэд шилжин ирэгчдийн хувь өндөр байдаг ч уг бүсээс Улаанбаатарын руу шилжих шилжилт мөн их байдаг байна. Эндээс үзвэл, Төвийн бүс нутаг нь Улаанбаатар руу шилжих хөдөлгөөний дамжлага шат болдог ажээ. Үүний дараа хүн амын ихээр шилжин ирдэг бүс нутагт Хангайн бүс ордог байна (ҮСГ, 2001; ХАЗССТ, 2001).

Иймээс Зүүн, Баруун болон Төвийн бүсүүдийн ажилгүйдлийн түвшний бууралт нь эдгээр бүс нутгуудаас шилжин явсан хүн амын шилжилтээс, Хангайн болон Улаанбаатарын бүсүүдийн ажилгүйдлийн түвшний өсөлт нь эдгээр бүс нутгуудад хүн ам ихээр шилжин ирсэнтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, тэдгээр бүс нутгуудийн ажилгүйдлийн түвшний бууралт нь бодит буюу ажлын байр шинээр байгуулагдсантай холбоогүй, чанарын бус харин тоон өөрчлөлтийн үр дүн болж байна.

### Бүс нутгуудийн ДНБ, түүний динамик шинжилгээ

ДНБ гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тодорхой хугацаанд (нэг жилд) дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бий болгосон нэмүү өртөг буюу эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний мөнгөн дүн,




эдийн засгийн үйл ажиллагааны үр дүн юм. Иймээс ДНБ-ийг бүс нутаг, аймгуудаар харьцуулан авч үзье.

1999-2003 оны ДНБ-ийг оны үнээр болон дүнд эзлэх хувиар тооцон үзэхэд, 2003 онд манай улс 1,461,169.2 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсний 111,622,1 сая төгрөгийг Баруун бүсэд, 259,493.2 сая төгрөгийг Хангайн бүсэд, 161,277.1 сая төгрөгийг Төвийн бүсэд, 80,176.8 сая төгрөгийг Зүүн бүсэд, үлдсэнийг буюу 848,650.0 сая төгрөгийг Улаанбаатарын бүсэд үйлдвэрлэсэн байна. Динамикийг харвал, Улаанбаатар, Зүүн, Төвийн бүсүүдийн ДНБ 1999-2003 онуудад өссөн бол Хангайн болон баруун бүсүүдэд хэлбэлзэлтэй ( $\pm$ ) байжээ.

Бүсүүдийн нэмэгдэл өртгийн (НӨ) ДНБ-д эзлэх хувийг үзвэл (Зураг 3) 2003 онд Улаанбаатар ихэнх буюу 58.1 хувь, 17.8 хувийг Хангайн бүсэд, 11.0 хувийг Төвийн бүсэд, 7.6 хувийг Баруун бүсэд, багахан хэсгийг буюу 5.5 хувийг Зүүн бүсэд үйлдвэрлэсэн байна. Улаанбаатарын бүсийн эзлэх хувийн жин жилээс жилд өсч, бусад бүс нутгийн хувийн жин буурсан байна.

Зураг 3. Бүсүүдийн ДНБ-д эзлэх хувь



Дээрх 5 жилээр нэмэгдэл өртөгт аймгуудын эзлэх хувийн жингийн өөрчлөлтийг бүс, аймгаар бүлэглэн харуулав.

**Хүснэгт 4.1 1999-2003 онд нэмэгдэл өртөгт эзлэх аймгуудын хувийн жингийн өөрчлөлт**

Бүс	Өөрчлөлт	Аймгийн нэр
Баруун	Өссөн	-
	Буурсан	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
	Хэлбэлзэлтэй	-
Хангайн	Өссөн	-
	Буурсан	Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл
	Хэлбэлзэлтэй	Орхон
Зүүн	Өссөн	Дорнод
	Буурсан	Хэнтий
	Хэлбэлзэлтэй	Сүхбаатар
Төв	Өссөн	-
	Буурсан	Дорноговь, Өмнөговь, Төв
	Хэлбэлзэлтэй	Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ
Улаанбаатар	Өссөн	Улаанбаатар

“Монгол улс зах зээлд” статистикийн эмхэтгэлээс харахад, Баруун болон Хангайн бүсийн хувийн жингийн эрчимтэй бууралт нь тэдгээрийн аймгууд тус бүрийн хувийн жингийн бууралтаас шалтгаалжээ. Төвийн бүсийн аймгуудын 50 хувь нь буурсан хандлагатай байсан боловч 50 хувь нь хэлбэлзэлтэй байсны улмаас уг бүсийн хувийн жин эрч багатайгаар буурсан байна. Зүүн бүсийн хувийн жин харьцангуй тогтвортой байгаа нь аймаг тус бүрийн жингийн өөрчлөлтийн чиглэл өөр өөр байгаатай холбоотой юм. 2003 оны байдлаар аймгуудын ДНБ-нд эзлэх хувийн жин хамгийн их (9.5 хувь) Орхон аймаг, хамгийн бага (0.3 хувь) Говьсүмбэр аймгуудийг оруулалгүйгээр тооцоход нэг аймаг дунджаар ДНБ-ний 1.7 хувийг үйлдвэрлэж байгааг 1999 оныхтой харьцуулахад 0.8 пунктээр буурчээ.

Бүсүүдийн 1999-2003 оны ДНБ-ний динамикийг 1995 оны зэрэгцүүлэх үнээр авч үзэхэд, Баруун бүсийн ДНБ нь дээрх онуудад жилд дунджаар 7.7 хувиар, Хангайн бүс 2.2 хувиар, Төвийн бүс 2.9 хувиар, Зүүн бүс 0.1 хувиар тус тус буурч байхад Улаанбаатарын бүс 7.5 хувиар өсчээ. Улаанбаатараас бусад бүсийн бууралт нь 1999-2000 онуудад бүх нутгуудыг хамарсан зудын уршгаар манай улсын голлох салбар болох хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг буурсантай холбоотой.

ДНБ-ийг салбараар нь авч үзье. Манай улсын ДНБ-ний 70 гаруй хувийг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай олборлох үйлдвэр, тээвэр агуулахын аж ахуй холбоо, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ салбарууд эзэлж байна. Өөрөөр хэлбэл, манай орны эдийн засгийн хөгжил тухайлбал, мал аж ахуйн салбар (сүүлийн 5 жилийн дунджаар хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг мал аж ахуй эзэлж байна), бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээврийн салбарын хөгжлөөс ихээхэн хамаарч байна.

1999-2003 оны динамикаас авч үзэхэд, хөдөө аж ахуйн салбарын хувийн жин жилд дунджаар 3.4 пунктээр буурч, уул уурхай олборлох үйлдвэрийн салбар 0.8 пунктээр, жижиглэн, бөөний худалдааны салбар 1.2 пунктээр, тээврийн салбар 0.9 пунктээр тус тус өсчээ. Энэ нь манай үйлдвэрлэлийн бүтцэд багахан өөрчлөлт орж байгааг илэрхийлж байна.

Манай улсын дээрх 3-н голлох салбаруудад бүсүүдийн эзлэх хувийг авч үзье. “Монгол Улсын Хүний Хөгжлийн Илтгэл” нэмэлт тоо материал (ҮСГ 2003 он) -аас харахад хөдөө аж ахуйгаас бусад бүх салбаруудын нэмэгдэл өртгийн 41-99 хувийг зөвхөн Улаанбаатарын бүс эзэлж байна. Энэ нь Улаанбаатарын бүс нь бусад эдийн засгийн бүсүүдээс эрс ялгаатай болохыг харуулж байна. Иймд судалгааны энэхүү хэсэгт Улаанбаатарын бүсийг оруулах шаардлагагүй хэмээн үзэж хаслаа.

Хөдөө аж ахуй ан агнуур, ойн аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн 25.4 хувийг Төвийн бүсэд, 24.6 хувийг Баруун бүсэд, 22.8 хувийг Хангайн бүсэд, 17.6 хувийг Зүүн бүсэд, 2.3 хувийг Улаанбаатарын бүсэд үйлдвэрлэсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн зонхилох хэсэг нь мал аж ахуйн секторт үйлдвэрлэгддэг. “Монгол улс зах зээлд статистикийн эмхэтгэл ҮСГ 2004 он”-оос харахад, малын тоо 1999-2002 онуудад бүх бүс нутгуудаар буурсан байна. 1999-2002 онуудад нэг аймгийн малын тоо жилд дунджаар 8.3 хувиар буурчээ. Энэхүү бууралтын бүс нутгаар авч үзвэл, баруун бүсэд хамгийн их буюу жилд дунджаар 11.6 хувиар, хангайн бүсэд 11.4 хувиар, төвийн бүс 8.3 хувиар тус тус буурч харин зүүн бүсэд жилд дунджаар 0.1 хувиар өссөн байв. Малын тооны өөрчлөлт нь аймгийн, цаашилбал бүсийн ДНБ-ний өөрчлөлтийн чиглэлтэй ижил байна. Өөрөөр хэлбэл, бүсүүдийн ДНБ-ний бууралт нь МАА-н салбарын үйлдвэрлэл буурсантай шууд холбоотой болохыг харуулж байна.

Уул уурхай олборлох үйлдвэрийн салбарын 54 хувийг Хангайн бүсийн Орхон аймагт, 41 хувийг Улаанбаатарт, бусад бүсүүдэд 0.2-4 хувийг бүрдүүлж байна.

Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарийн нэмэгдэл өртөгт Төвийн бүс 7.5 хувь, Хангайн бүс 7 хувь, Зүүн бүс 2.7 хувь, Баруун бүсэд 2.6 хувийн хувь нэмрийг оруулжээ. Үлдсэн буюу 80 хувийг Улаанбаатарт үйлдвэрлэсэн байна.

Тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгийн 4.9 хувийг Төвийн бүсэд, 4.4 хувийг Хангайн бүсэд, 3.5 хувийг Баруун бүсэд, 1.6 хувийг Зүүн бүсүүдэд үйлдвэрлэжээ. Улаанбаатараас бусад бүсүүдийг харьцуулан үзэхэд Хангайн болон Төвийн бүсүүдэд эдийн засгийн салбаруудын нэмэгдэл өртгийн 70-95 хувийг үйлдвэрлэж байна. Эндээс үзэхэд, Хангайн болон Төвийн бүсүүд нь

эдийн засгийн бүтэц, хөгжил, чадавхиараа ойролцоо түвшинд байгаа нь харагдаж байна.

Дээрх үзүүлэлтүүдийг бүсүүдээр авч үзвэл, (Баруун бүсийн ДНБ-ний 2/3 (65 хувь)-ийг хөдөө аж ахуйн салбарт, 15 хувийг тээвэр худалдааны салбарт үйлдвэрлэж байна. Хангайн бүсийн ДНБ-ний 83 хувь нь хөдөө аж ахуй (34 хувь), уул уурхай олборлох (38 хувь), худалдааны (11 хувь) салбаруудад ногдож байна. Төвийн бүсийн ДНБ-ний 70 хувийг хөдөө аж ахуйн (46 хувь), тээврийн (6хувь), худалдааны (18 хувь) салбаруудад үйлдвэрлэж байна. Зүүн бүсийн хувьд хөдөө аж ахуйн салбарт ДНБ-ний 65 хувийг, 13 хувийг худалдааны салбарт, тээвэр холбооны салбарт 4 хувийг буюу нийтдээ 80 гаруй хувийг дээрх 3-н салбарт үйлдвэрлэж байна. Харин Улаанбаатарын ДНБ-ний 37 хувийг худалдааны, 20 хувийг тээврийн, 18 хувийг боловсруулах уул уурхай олборлох салбар эзэлж байна.

Одоо бүс доторх аймгуудаар авч үзье.

Баруун бүс: Баруун бүсийн аймгуудын "бүсийн ДНБ"-нд оруулсан хувь ижил тэнцүү байна (Говь-Алтай аймгаас бусад). Тус бүсийн голлох салбар болох хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөгт мөн л тэнцүү хувь нэмэр оруулдаг бол худалдааны салбарт Баян-Өлгий, Увс аймгууд голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

1. Хангайн бүс: Тус бүсийн голлох салбар болох уул уурхай олборлох үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг Орхон аймагт бүрдүүлж байна. Мал аж ахуйн нэмэгдэл өртөгт Хөвсгөл, Өвөрхангай, Булган аймгууд голлох нөлөөг үзүүлжээ. Мөн худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хувьд Орхон аймаг давамгайлж байна.

2. Төвийн бүс: Төвийн бүсийн голлох салбар болон мал аж ахуй салбарын нэмэгдэл өртгийн 80-аад хувийг Сэлэнгэ, Дундговь, Төв аймгуудад үйлдвэрлэжээ. Худалдааны салбарын нэмэгдэл өртөгт Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд, тээвэр холбооны салбарт Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймаг зонхилж байна. Онцлон тэмдэглэхэд, Дархан-уул аймаг цахилгаан дулаан үйлдвэрлэлээрээ Улаанбаатарын дараа орж байна.


3. Зүүн бүс: Голлох салбар болох мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөгт Сүхбаатар, Хэнтий аймаг, худалдааны салбарын нэмэгдэл өртөгт Дорнод аймаг зонхилох үүрэг гүйцэтгэж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд зааснаар бүсүүдийн тулгуур төвөөр Өвөрхангайн Хархорин, Орхон аймгийн Эрдэнэт, Төв аймгийн Зуунмод, Дархан-Уул аймгийн Дархан, Хэнтий аймгийн Өндөрхаан, Дорнодын Чойбалсан хотуудыг сонгосон нь тус бүсэд эдийн засгийн хувьд голлох үүрэг гүйцэтгэдэг аймгуудтай нийцэж байна.

Аж үйлдвэрийн хөгжил бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Энэ нь манай улсын боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн


үйлдвэрлэлд бүс нутгуудын оруулж байгаа хувь нэмрээс тодорхой харагддаг. Өнөөгийн байдлаар боловсруулах аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 80.1 хувь нь Улаанбаатар хотод, 9.4 хувь нь Төвийн бүсэд 5.9 хувь нь Хангайн бүсэд, 1.8 хувь нь Баруун бүсэд, 2.5 хувь нь Зүүн бүсэд тус тус ногдож байгаа нь Улаанбаатараас бусад бүсүүдэд аж үйлдвэрийн салбарын хөгжил дорой байгааг харуулж байна. Нэг хүнд ногдох ДНБ нь тухайн газар нутгийн хүн амын амьжиргааны түвшинг харуулдаг үзүүлэлт тул түүнийг бүсүүдээр авч үзье. Зураг 4-өөс харахад 2003 онд нэг хүнд ногдох ДНБ Улаанбаатарт хамгийн их 975515.8 төгрөг, Баруун бүсэд хамгийн бага 268064.6 төгрөг байна. Бүсүүдийн нэг хүнд ногдох ДНБ-ийг улсын дундажтай харьцуулан үзэхэд Улаанбаатарын бүс нь улсын дундажаас 1.7 дахин их, Зүүн бүс 0.7 дахин, Хангайн бүс 0.8 дахин, Баруун бүс 0.5 дахин, Төвийн бүс 0.6 дахин бага байна.

Зураг 4. Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр



Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтийн хурдыг бүсүүдээр авч үзвэл Улаанбаатарын бүсэд жилд дунджаар 97685.9 төгрөгөөр буюу 13.9 хувиар өсч байна. Зүүн бүсийн хувьд 28903.7 төгрөгөөр буюу 9.0 хувиар, Төвийн бүс 13737 төгрөгөөр буюу 4.2 хувиар, Хангайн бүс 26666.2 төгрөгөөр буюу 6.7 хувиар, Баруун бүс 6059.4 төгрөгөөр (9.9 хувиар) тус тус өсч байна.

Зураг 5. Нэг хүнд ногдох ДНБ, 1995 оны үнээр



Нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлтийн хурдыг бүсүүдээр тооцоход (Зураг 5) Улаанбаатарт жилд дунджаар 6.2 хувиар, Зүүн бүсэд 1.8 хувиар өсч, Баруун бүсэд 4.3 хувиар, Төвийн бүсэд 2.7 хувиар, Хангайн бүсэд 0.3 хувиар буурсан байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ний энэхүү өсөлт, бууралт бүс хоорондын шилжих хөдөлгөөний улмаас бий болсон чанарын бус, тоон өөрчлөлт гараад байна уу гэдгийг индексийн аргыг ашиглан тооцон үзье.

Үүнд:  $GDP_0$ ,  $GDP_1$  - суурь болон тайлант үеийн ДНБ

$N_0$ ,  $N_1$  - суурь болон тайлант үеийн жилийн дундаж хүн ам

$$J_{GDP/N} = \frac{GDP_1}{N_1} : \frac{GDP_0}{N_0} \quad J_{GDP/N}(N) = \frac{GDP_0}{N_1} : \frac{GDP_0}{N_0} \quad J_{GDP/N}(GDP) = \frac{GDP_1}{N_1} : \frac{GDP_0}{N_1}$$

Аймгууд	2000/1999			2001/2000			2002/2001			2003/2002		
	J N	J GDP	J	J N	J GDP	J	J N	J GDP	J	J N	J GDP	J
Баруун	1.01	0.938	0.948	0.999	0.913	0.912	1.002	0.874	0.876	1.009	1.095	1.105
Хангайн	0.994	1.082	1.075	0.988	0.7	0.692	0.996	1.093	1.089	1.006	1.211	1.218
Төв	0.998	0.791	0.789	0.997	1.116	1.112	0.996	0.999	0.995	1.005	1.024	1.029
Зүүн	1.012	0.896	0.907	1	0.992	0.992	0.997	1.06	1.056	1.001	1.129	1.131
Улаанбаатар	0.954	1.08	1.03	0.967	1.15	1.113	0.964	1.061	1.022	0.954	1.137	1.084
Улс	0.986	1.011	0.996	0.986	1.01	0.996	0.986	1.04	1.026	0.988	1.132	1.118

Хүснэгтээс харахад 2003 оны нэг хүнд ногдох ДНБ-ийг 2002 оныхтой харьцуулахад Баруун бүсийн хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам буурсан) нэг хүнд ногдох ДНБ 0.9 хувиар, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 9.5 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 10.5 хувиар өсчээ. Хангайн бүсийн хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам буурсан) нэг хүнд ногдох ДНБ 0.6 хувиар, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 21.1 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 21.8 хувиар өссөн байна. Төвийн бүсийн хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам буурсан) нэг хүнд ногдох ДНБ 0.5 хувиар, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 2.4 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 2.9 хувиар өсчээ. Зүүн бүсийн хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам буурсан) нэг хүнд ногдох ДНБ 0.1 хувиар, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 12.9 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 13.1 хувиар өсчээ. Улаанбаатарын бүсийн хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам өссөн) нэг хүнд ногдох ДНБ 1.2 хувиар буурч, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 13.2 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 8.4 хувиар өсчээ.

Нийт улсын хувьд хүн амын тооны өөрчлөлтөөс (хүн ам өссөн) нэг хүнд ногдох ДНБ 1.2 хувиар буурч, бүсийн ДНБ-ний өөрчлөлтөөс (өсөлтөөс) нэг хүнд ногдох ДНБ 13.2 хувиар нэмэгдсэний дүнд бүсийн нэг хүнд ногдох ДНБ 11.8 хувиар өсчээ.

Дээрхээс харахад, нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт, бууралтанд тухайн бүсийн хүн амын тооны өөрчлөлтийн нөлөө бага байна. Иймээс дээрх өсөлт, бууралт нь тухайн бүсэд үйлдвэрлэгдсэн ДНБ-ний өөрчлөлтөөс шалгаалсан чанарын өөрчлөлтийн үр дүн юм. Гэхдээ, бүсийн үйлдвэрлэл нэмэгдэх хандлага буйг илэрхийлж байна.

Манай орон нь газар зүйн маш олон онцлог шинж бүхий бүс нутагтай, бүс нутаг бүр цаг уур, ургамал, амьтны аймгийн хувьд өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Энэ онцлог шинжүүд нь эдийн засгийн хөгжлийн байдал хүн амын амьжиргааны түвшин улсын хэмжээгээр ямар байгааг тодорхойлоход чухал нөлөөтэй юм. Тиймээс Үндэсний статистикийн газар, Дэлхийн банк, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжигдэн хийгдсэн "Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа"-нд ядуурал ба газар зүйн байршил хоёр хоорондоо ямар хамааралтай байгааг авч үзжээ.

Тайланд тусгасанаар, ядуурлын байдал бүс нутгуудын хувьд нэлээд ялгаатай байна. Ядуурлын хэмжигдэхүүнүүдийг газар зүйн байршлаар нь доорх хүснэгтэнд үзүүлэв. Судалгааны дүнгээр нутгийн зүүн хэсэгт ядууралд бага өртөж байгаа хандлага ажиглагдаж байна. Баруун бүсэд хүн амынх нь талаас илүү хувь, Хангайн бүсийн хүн амын бараг тавны хоёр, Төвийн болон зүүн бүсийн хүн амын тус бүр гуравны нэг орчим хувь нь ядуу байна. Улаанбаатар хотын хувьд бусад бүсүүдтэй харьцуулахад ядуурлын хүрээ

хамгийн бага буюу нийслэлийн хүн амын дөрөвний нэг гаруй нь нэн ядуу байна. Баруун бүс нийт хүн амын зургааны нэгийг бүрдүүлж байгаа боловч ядуу хүн амын дөрөвний нэгийг эзлэж байна. Үүний эсрэгээр харин нийт хүн амын гуравны нэг нь амьдарч байгаа нийслэл хотод ядуу хүн амын тавны нэг орчим нь амьдарч байна. Ядуу хүн амын дөрөвний нэг нь мөн Хангайн бүсэд, тавны нэг нь Төвийн бүсэд, үлдсэн аравны нэг хувь нь Зүүн бүсэд тус тус амьдарч байна.

**Хүснэгт 6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүс нутгаар**

Үзүүлэлтүүд	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
Ядуурлын хамралтын хүрээ	36.1	51.1	38.7	34.4	34.5	27.3
Ядуурлын гүнзгийрэлт	11.0	14.6	12.3	10.1	12.4	8.1
Ядуурлын мэдрэмж	4.7	5.7	5.2	4.3	6.6	3.3
<b>Нэмэлт үзүүлэлтүүд</b>						
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (хувь)	100.0	24.0	25.8	18.6	8.9	22.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын тоо (мян.хүн)	864.0	214.4	230.5	166.3	79.1	203.8
Хүн амын хувийн жин (хувь)	100.0	17.0	24.1	19.5	9.3	30.2
Хүн амын тоо (мян.хүн)	2475.4	419.8	596.1	783.4	229.0	747.3
Өрхийн ам бүлийн тоо (мян.хүн)	4.3	4.6	4.1	4.1	4.4	4.4
Хотжилт (хувь )	55.4	34.8	31.3	40.6	42.0	100.0

Эх сурвалж: Өрхийн орлого зрлага амьжиргааны түвшний судалгаа, ҮСГ, 2002-2003.

Энэ тооцоонд анхаарч авч үзэх бас нэгэн хүчин зүйл бол хотжилт юм. Жишээлбэл, ядуурлын түвшин, хүрээ хамгийн ихтэй байгаа Баруун болон Хангайн бүсэд хотжилт бага байна. Ерөнхийдөө хөдөөгийн хөгжлийн түвшин хотоос доогуур байдаг тул амьжиргааны түвшин ч тэнд доогуур байдаг. Хотыг хөдөөтэй харьцуулбал ядуурал харьцангуй бага байгаа буюу 30 хувь, харин хөдөөд 43 хувь байна.

Хотыг суурьшлаар нь авч үзэхэд ядуурлын хамралтын хүрээ Улаанбаатар хотод аймгийн төвүүдээс доогуур байна. Харин хөдөөгийн суурьшлын хооронд өөрөөр хэлбэл, сумын төв болон хөдөөд ядуурлын хамралтын хүрээ ойролцоо байгаа хэдий ч сумын төвтэй харьцуулахад хөдөөд нь ядуурлын түвшин бага байна. Нийт хүн амын 55 хувь нь амьдардаг хот суурин газарт ядуу хүн амын дөнгөж 45 хувь нь амьдарч байхад хөдөөд эсрэгээрээ байна. Ядуучуудын гуравны нэг хувь нь хөдөөд, дөрөвний нэг аймгийн төвд, тавны нэг нь сумын төвд амьдарч байна гэсэн үр дүн гарсан байна. Үүнээс үзэхэд, хаана нэг хүнд ногдох ДНБ бага, аж үйлдвэржилтийн түвшин дорой байгаа тэр л газар ядуурал их байна. Үүнийг Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ жилээс жилд эрчимтэй буурч байгаагаар тайлбарлаж болох юм. Мөн шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн хөгжлийн ердийн үзэгдэл бүс хоорондын ялгаатай байдлыг бууруулах чухал арга хэрэгсэл боловч шилжин очсон газарт нь ажил эрхлэх, орлого олох боломж байхгүй




бол энэ нь бүс хоорондын аль алиных нь ядуурлын түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд хүргэдэг.

Эдийн засгийн бүсүүдийн эдийн засгийн дэд бүтцийн хөгжил, өнөөгийн байдал, үнэлгээний талаар хийгдсэн судалгааны үр дүнг товч авч үзье. Эдийн засгийн бүсүүдээр улсын чанартай авто замын байршил нь Баруун бүсэд 4008.0 мян/км, Хангайн бүсэд 2598.0 км мян/км, Төвийн бүсэд 2418.0 мян/км, Зүүн бүсэд 1984.0 мян/км, Улаанбаатар хотод 113.0 мян/км харин төмөр замын урт нь төвийн бүсэд 1413.7 мян/км, Улаанбаатарын 112.0 мян/км, Хангайн 41.0 мян/км, Зүүн бүсийн 1812.7 мян/км байдаг. Усан замын байршлыг авч үзвэл зөвхөн Хангайн болон Төвийн бүсэд л усан зам байдаг.

Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийг эдийн засгийн бүсүүдээр дээрх үзүүлэлтүүд, мөн хүн амын тоо, ДНБ-ий хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан замын сүлжээний хангамжийн үнэлгээг<sup>10</sup> бүс тус бүрээр авч үзье.

**Зураг ба. Төрөл бүрийн замын сүлжээний хангамж (эдийн засгийн бүсүүдээр)**



1. Баруун бүсийн замын сүлжээний хангамжийн үнэлгээ  
Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээний үр дүнд Баруун бүс хамгийн доогуур үзүүлэлттэй (0.13) буюу Төвийн бүсийнхээс 12.4 дахин, Хангайн бүсийнхээс 6.8 дахин, Зүүн бүсийнхээс 4.8 дахин бага байгаа ба энэ нь тус бүсэд хатуу хучилттай авто замын болон төмөр замын сүлжээ байхгүй, замын бартаа ихтэй, төвөөс алслагдсан, замын харилцаа сул хөгжсөнтэй холбоотой юм.


<sup>10</sup>  $d = \frac{L}{\sqrt{s \cdot p \cdot GDP}}$  үүнд: d- замын сүлжээний хангамжийн үнэлгээний коэффициент

L - замын шилжүүлсэн нийт урт  
S - нутаг дэвсгэрийн талба P - хүн амын тоо  
GDP- ДНБ

## 2. Хангайн бүсийн замын сүлжээний хангамжийн үнэлгээ

Хангайн бүс нь төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үзүүлэлтээр (0.89) Төвийн бүсийн дараа ордог. Тус бүс Төвийн бүсийн энэ үзүүлэлтээс 1.8 дахин бага, харин Зүүн бүсээс 1.4 дахин, Баруун бүсээс 6.8 дахин их байна. Хангайн бүсийн аймгууд нь энэ үзүүлэлтээр хоорондоо нэлээд ялгаатай бөгөөд Орхон аймаг бүс дотроо нэгдүгээрт ордог. Дархан-Эрдэнэтийн төмөр зам болон авто зам нь бүсийн зорчигч, ачаа эргэлтэд чухал ач холбогдолтой байдаг. Мөн Мянганы замын зэрэгцээ Улаанбаатараас Баруун бүс рүү чиглэсэн улсын чанартай авто зам тус бүсийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг.

Зураг 6б. Замын сүлжээний хангамжийн нэгдсэн үнэлгээ, аймгуудаар



## 3. Төвийн бүсийн сүлжээний хангамжийн үнэлгээ

Төвийн бүсэд бусад бүсүүдийг бодвол Ази, Европыг холбосон төмөр зам, авто зам тус бүрийг дайран өнгөрдөг учир үйлдвэрлэлийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Үнэлгээгээр (1.61) авч үзвэл замын сүлжээний хангамж Баруун бүсээс 12.3 дахин, Зүүн бүсээс 2.5 дахин, Хангайн бүсээс 1.8 дахин их байна. Төвийн бүсийн аймгууд нь замын сүлжээний хангамжаар дотооддоо төдийгүй, улсын хэмжээнд тэргүүдэг нь манай улсын төмөр зам болон сайн чанарын авто замын гол тэнхлэг эдгээр аймгуудын нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөгтэй холбоотой.

## 4. Зүүн бүсийн замын сүлжээний хангамжийн үнэлгээ

Зүүн бүсийн авто замын сүлжээг Чойбалсан Эрэнцавын төмөр зам, мөн улсын чанартай авто зам, орон нутгийн чанартай бусад хөрсөн зам бүрдүүлж байна.

Тус бүс төрөл бүрийн замын сүлжээний хангамжаар (0.63) Төвийн болон Хангайн бүсийн дараа ордог. Дорнод аймаг замын сүлжээний хангамжаар бүсдээ түрүүлдэг бөгөөд улсын хэмжээнд нэлээн дээгүүр байр эзэлдэг.

Монгол Улсын төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн өнөөгийн байдлыг бүхэлд нь авч үзвэл бүс нутгуудаар өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Энэ нь тухайн бүсийн эдийн засгийн хөгжил, үйлдвэрлэлтэй шууд хамааралтай байна.

*Эрчим хүчний салбарын хөгжлийн өнөөгийн байдал, үнэлгээны хувьд:* Одоогоор манай улсад 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам 1037.1 км, 110 кВ-ын шугам 2800 гаруй км, 35 кВ-ын шугам 4896.1 км, 1-20 кВ-ын шугам 2443.4 км тус тус байна. Гол хуваарилах дэд өртөөнүүд Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Багануур, Чойр хотуудад байршиж, үндсэн үүсгүүр болох Улаанбаатарын ТЭЦ-4, ТЭЦ-3 болон ОХУ-ын Сибирийн эрчим хүчний систем бүрдүүлж байна. Төвийн эрчим хүчний системийн хүрээнд одоогийн байдлаар Улаанбаатар хот, 11 аймгийн зарим сумдын нутаг, улсын хүн амын 62.5 хувь, нийт нутаг дэвсгэрийн 24 орчим хувь хамрагдаж байна.

Улсын ДНБий 2.8 хувийг эрчим хүчний салбарт үйлдвэрлэж байна. Эдийн засгийн макро бүсүүдээр авч үзвэл улсын нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 15хувийг Төвийн бүс, 2.6 хувийг Баруун бүс, 3.4 хувийг Зүүн бүс, 73 хувийг Улаанбаатарын бүс, 5.7 хувийг Хангайн бүс тус тус үйлдвэрлэж байна.

## **Бүс нутгуудийн шинжилгээ**

### **Регрессийн шинжилгээ**

**А.** Тухайн аймгийн ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувьд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судаллаа. Судалгааны өмнөх хэсгүүдийн үр дүнд харгалзан үндсэн загварыг дараах байдлаар сонгов:

$$Y_i = b_0 + b_1 X_1 + b_2 X_2 + b_3 X_3$$

үүнд:  $Y_i$  - аймгуудын ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувь

$X_1$ - аймгийн төсвийн зарлага

$X_2$ - аймгийн ХАА-н салбарын НӨ

$X_3$ - аймгийн ажиллагсдын тооны өсөлт

*а. Аймгуудын ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувь*

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтын хүрээнд аймгууд эдийн засгийн өнөөгийн нөөц бололцоондоо тулгуурлан өөрийн аймгийн нийт ДНБ-нд эзлэх хувийг нэмэгдүүлж, зорилтоо биелүүлэх боломжтой юм. Статистикийн хувьд найдвартай, хазайлтгүй үнэлгээ гаргахын тулд судалгаандаа Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр аймгуудыг оруулаагүй болно.

*б. Аймгийн төсвийн зарлага*

Төсвийн зарлага нь төрөөс эдийн засгийн зохицуулах гол үүрэг гүйцэтгэдэг. Эдийн засгийн макро түвшний тэнцвэржилтийг хангах, нийгмийн өргөтгөсөн нөхөх үйлдвэрлэлийг явуулах санхүүгийн нөхцлийг бүрдүүлэх, төсвийн зарлагаар дамжин төрийн мэдэлд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг нийгэм эдийн засгийн бүс салбар, хүн амд хүргэх үйлчилгээ үзүүлэхээр хувиарлах үүрэг гүйцэтгэдэг. Мөн үнэ, нөөцийн байршил, ажил эрхлэлт, үйлдвэрлэл болон орлогын хуваарилалтанд улсын зарлага нөлөөлдөг зэргийг анхааралдаа авбал төсвийн зарлагын хэмжээг хүчин зүйлээр сонгох нь зүйтэй юм. Шинжилгээндээ 1999-2003 оны аймгуудын төсвийн зарлагын дунджийг ашигласан нь статистикийн хувьд илүү найдвартай үр дүн гарахад нөлөөлсөн.

*в. Аймгийн ХАА-н салбарын нэмүү өртөг (НӨ)*

Өмнө үзүүлсэнчлэн аймгуудын ДНБ-ний дийлэнх хувийг ХАА-н салбар үйлдвэрлэдэг билээ. Иймд аймгийн ХАА-н салбарын НӨ-ийг хүчин зүйл болгон сонгон авсан бөгөөд 1999-2003 оны аймгуудын ХАА-н салбарын НӨ-ийн дунджийг ашигласан нь статистикийн хувьд илүү найдвартай үр дүн гарахад нөлөөлөв.

*г. Аймгийн ажиллагсдын тооны өсөлт*

Үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйл болох аймгуудын ажиллагсдын тооны 1999-2003 оны жилийн дундаж өсөлтийг сонгон авсч ажилчдын тооны өөрчлөлт тухайн аймгийн эдийн засагт хэрхэн нөлөө үзүүлж байгааг тодорхойлох зорилт тавилаа.

Загварыг дээрх 4 хүчин зүйлээс хамааруулан тооцоход үр дүнгүй гарсан ба загварыг сайжруулсны дүнд дараахь үр дүн гарсан:

**Хүснэгт 7. Ажилчдын тооны өөрчлөлт, аймгийн эдийн засагт үзүүлэх нөлөө, шинжилгээний үр дүн**

Үзүүлэлтүүд	Утга
Корреляцийн коэффициент R	0.9701
Дитерминацийн коэффициент R <sup>2</sup>	0.9412
Засварлагдсан дитерминацийн коэффициент R <sup>2</sup>	0.9343
Фишерийн шинжүүр F(2,17)	136.07
P утга	0.0000
Үнэлгээний стандарт алдаа Se	0.5357

**Хүснэгт 8. Ажилчдын тооны өөрчлөлт, аймгийн эдийн засагт үзүүлэх нөлөө, шинжилгээний үр дүн**

Үзүүлэлтүүд	Коэффицинтууд	Стандарт алдаа	t шинжүүр	p утга
Аймаг төсвийн зарлага/ аймаг ДНБ	0.131291	0.039939	3.287289	0.004348
Аймаг ХАА/аймаг ДНБ	0.015508	0.004793	3.235861	0.004858

Үнэлсэн регрессийн тэгшитгэлийг бичвэл:

$$Y_i = 0.01X_1 + 0.13X_2$$

t стат (3.23) (3.29)

Загварын хувьд аймгуудын ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувь нь нэг, хоёрдугаар хүчин зүйлээс хүчтэй хамааралтай байна (R= 0.97). Дитерминацийн коэффициент 0.94 гарсан нь аймгуудын ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувийн нийт хэлбэлзлийн 94.1 хувийг өмнөх хоёр хүчин зүйлийг нөлөөлөл гэж тайлбарлаж болно. Эх олонлогийн регрессийн параметрууд нэгэн зэрэг тэгтэй тэнцүү гэсэн тэг таамаглал няцаагдаж (F(0.05, 2,17)=136.1 p<0.00000), өрсөлдөгч таамаглал болох эх олонлогийн регрессийн параметрууд нэгэн зэрэг тэгээс ялгаатай таамаглалыг хүлээн авч байна. Өөрөөр хэлбэл, сонгон авсан хүчин зүйлүүд бүгд нөлөөтэй гэсэн таамаглалын хүлээн авч байна.

Нэгдүгээр хувьсагчийн параметр нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Эх олонлогийн хувьдах хоёрдугаар хувьсагчийн параметр тэгтэй тэнцүү буюу нөлөөгүй гэсэн тэг таамаглалыг няцааж (p<0.0043), нөлөөтэй гэсэн альтернатив таамаглалыг хүлээн авна.

Хоёрдугаар хувьсагчийн параметр нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Эх олонлогийн хувьдах хоёрдугаар хувьсагчийн параметр тэгтэй тэнцүү буюу нөлөөгүй гэсэн тэг таамаглалыг няцааж ( $p < 0.0048$ ), нөлөөтэй гэсэн альтернатив таамаглалыг хүлээн авна. Иймээс тус загвар статистикийн хувьд бүрэн ач холбогдолтой гарлаа. Загварын параметруудийг харахад аймгийн ДНБ-нд эзлэх ХАА-н салбарын хувийн жин 1 хувиар нэмэгдэхэд аймгийн ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувийн жин 0.015 хувиар, аймгийн ДНБ-нд эзлэх төсвийн зарлагын хувийн жин 1 хувиар нэмэгдэхэд аймгийн ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувийн жин 0.13 хувиар нэмэгдэхээр байна. Эндээс үзэхэд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн хувийн жингээс төсвийн зарлагын хувийн жин илүү нөлөөтэй болох нь харагдаж байна.

### **Кластер, компонентийн шинжилгээ**

Энэхүү шинжилгээг к-дунджийн кластерийн аргаар хийлээ. Кластерийн шинжилгээгээр аймгуудыг сонгон авсан эдийн засгийн үзүүлэлтүүдээр нэг төрөл байх бүлгүүд болгон хуваарилан үзэхдээ *Аймгийн ДНБ-нд эзлэх ХАА-н НӨ-ийн хувь*, *Хүн ам зүйн ачаалал*, *Аймгийн ДНБ-нд эзлэх татаасын хувь*, *Ажиллах хүчний оролцооны түвшин*, *нэг хүнд ногдох ДНБ (2001-2003 мян.төг)*- ийг ашиглав. Шинжилгээний үр дүнг бодитой байлгахын тулд бусадтай харьцуулахад өвөрмөц онцлог бүхий нөлөө үзүүлэх аймгуудыг хассан болно. Үүнд: Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр, Дундговь аймгууд болно. Тооцооллыг STATISTICA 6.0, OLYMP 4.0 багц программуудыг ашиглан гүйцэтгэсэн. Гурван (их, дунд, бага гэсэн утгаар) бүлэг болгон бүлэглэж дараах тооцооллыг хийв. Үүнд:

I бүлэгт: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Дорнод

II бүлэгт: Булган, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар, Дархан-Уул, Хэнтий

III бүлэгт: Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгууд орж байна. Энэ бүлэглэлтийн дүнд бүлэг доторх аймгууд бие биетэйгээ хамгийн ойр (ижил төсөөтэй), харин бүлгүүд нь хоорондоо хамгийн их ялгаатай байхаар хувиарлагдсан. Дээрх бүлгүүдийг өмнө сонгосон зарчимдаа нийцүүлэхийн тулд дараах хүснэгтийг ашигласан.

**Хүснэгт 9. К дундаж кластерийн аргын үнэлгээ**

Аймаг	Нэг хүнд ногдох ДНБ 2001 ,төг	Нэг хүнд ногдох ДНБ 2002 төг	Нэг хүнд ногдох ДНБ 2003 төг	Ажиллах хүчний оролцооны түвшин,	Аймгийн ДНБ-нд эзлэх татаасын хувь,	Хүн ам зүйн ачаалал	Аймгийн ДНБ-нд эзлэх ХАА-н НӨ- ийн хувь
<b>I БҮЛЭГ</b>							
Баян-Өлгий	126801.5	115452.1	130453.1	92.9	11.7	94.7	63.7
Говь-Алтай	190003.9	104786.2	112280.5	94.2	15.8	97.1	68.2
Завхан	124864.6	139645.6	147174.3	93.9	11.1	63.3	74.5
Увс	133282.0	133444.6	157659.7	95.4	12.3	74.8	68.7
Ховд	152059.8	127570.7	137783.9	95.7	10.0	82.5	85.4
Архангай	169707.2	176664.0	145822.8	95.6	6.9	75.4	75.4
Баянхонгор	186845.9	85991.2	95475.5	93.9	11.3	71.1	76.5
Дорнод	128919.9	160424.0	181920.2	90.5	11.8	66.7	59.4
Бүлгийн дундаж	151560.6	130497.3	138571.2	94.0	11.4	81.9	71.5
<b>II БҮЛЭГ</b>							
Булган	223324.6	209737.6	171732.4	93.8	7.6	92.2	72.6
Хөвсгөл	234654.0	207366.3	219911.9	96.8	8.5	73.2	75.2
Өмнөговь	203507.3	196998.0	190819.5	97.3	11.1	67.7	50.6
Сүхбаатар	194159.4	201655.0	248696.4	96.5	10.4	71.1	75.9
Дархан-Уул	254408.0	229528.8	196258.6	96.7	3.4	68.8	43.5
Хэнтий	196207.8	184814.0	192075.2	94.7	8.8	74.2	68.2
Бүлгийн дундаж	217710.2	205016.6	203249.0	96.0	8.3	86.2	64.3
<b>III БҮЛЭГ</b>							
Өвөрхангай	106192.4	93103.5	99510.8	95.3	9.3	76.4	70.4
Дорноговь	37369.2	51390.8	44240.1	94.4	9.6	67.7	24.6
Сэлэнгэ	82005.6	97822.7	108645.3	96.3	4.5	68.8	56.9
Төв	92086.3	75866.7	84895.0	97.4	6.8	65.6	56.1
<b>Бүлгийн дундаж</b>	<b>79413.4</b>	<b>79545.9</b>	<b>84322.8</b>	<b>95.8</b>	<b>7.6</b>	<b>69.6</b>	<b>52.0</b>

Дээрх хүснэгтийг ашиглан үзүүлэлт тус бүрийг бүлгүүдэд харгалзуулан их=3, дунд=2, бага=1 гэсэн тэмдгээр эрэмбэлж тооцоход I бүлгийг дунд, II бүлгийг их, III бүлгийг бага бүлэг гэж үзэх боломжтой болсон.

**Хүснэгт 10. К дундаж кластерийн аргын үнэлгээ, бүлгэлсэн байдлаар**

	Нэг хүнд ногдох ДНБ- ний 3 жилийн дундаж, төг	Ажиллах хүчний оролцооны түвшин	Аймгийн ДНБ- нд эзлэх татаасын хувь	Хүн ам зүйн ачаалал	Аймгийн ДНБ-нд эзлэх ХАА-н НӨ-ийн хувь	<b>Үнэлгээ</b>
I БҮЛЭГ	дунд	бага	их	дунд	их	ДУНД
II БҮЛЭГ	их	их	дунд	их	дунд	ИХ
III БҮЛЭГ	бага	дунд	бага	бага	бага	БАГА

Аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ нь тэдгээрт олгож байгаа татаасын хэмжээ, хүн ам зүйн ачаалалтай урвуу, аймгийн ДНБ-нд эзлэх ХАА-н нэмэгдэл өртөг, ажиллах хүчний оролцооны түвшинтэй шууд

хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, тухайн аймгийн нэг хүнд ногдох ДНБ өндөр байх тусам түүнд олгох татаас харьцангуй бага, хөдөлмөрийн насны хүн амын ихээхэн хэсэг ажиллах тусам тухайн аймгийн нэг хүнд ногдох ДНБ их байна. Бүлгүүдийн хувьд тооцсон дундажуудын бие биенээсээ ялгаатай байгаа байдал нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан.

Шинжилгээний үр дүнгээс дараах шинж байдал ажиглагдсан.

**Их бүлэг:** Харьцуулалтыг судалгаанд хамрагдсан 18 аймгийн хувьд тус тусад нь авч үзье.

Булган аймаг: Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 12-рт, цахилгаан дулааны үйлдвэр, усан хангамжийн салбарын НӨ-өөрөө 4-рт, худалдааны НӨ-өөрөө 5-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 13-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний дийлэнхийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад их биш байх боловч Булган аймгийн хүн амын тоо 11-рт (харьцангуй бага) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Хөвсгөл аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 1-рт, худалдааны НӨ-өөрөө 8-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 2-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 80-иад хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад өндөр байх боловч Хөвсгөл аймаг хүн амын тоогоороо 1-рт (харьцангуй бага) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Өмнөговь аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 17-рт, уул уурхай, олборлох үйлдвэрийн НӨ-өөрөө 1-рт, худалдааны НӨ-өөрөө 14-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 1-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний дийлэнхийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад их биш байх боловч Өмнөговь аймаг хүн амын тоогоороо хамгийн сүүлд (хамгийн бага) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Сүхбаатар аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 3-рт, худалдааны НӨ-өөрөө 9-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 85 хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад их биш байх боловч Сүхбаатар аймаг хүн амын тоогоороо 15-рт (харьцангуй бага) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Дархан-Уул аймаг Тус аймаг нь цахилгаан дулааны үйлдвэр, усан хангамжийн салбарын НӨ-өөрөө улсдаа 1-рт, худалдааны НӨ-өөрөө 1-рт, боловсруулах үйлдвэрийн НӨ-өөрөө 1-рт, барилгын салбарын нэмэгдэл өртгөөрөө 1-рт, уул уурхай, олборлох үйлвэрийн НӨ-өөрөө 2-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 70 хувийг бүрдүүлдэг юм. НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад их боловч Дархан-Уул аймаг



хүн амын тоогоороо 8-рт (дундаж) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Хэнтий аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 5-рт, худалдааны НӨ-өөрөө 9-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 17-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний дийлэнхийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэр бусадтай харьцуулахад их биш байх боловч Хэнтий аймаг хүн амын тоогоороо 13-рт (харьцангуй бага) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр гарч байна.

Энэ бүлэгт орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг бусад бүлэгтэй харьцуулахад өндөр, хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь бага байна. Энэ нь бүлэгт орсон аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, дулаан цахилгааны үйлдвэр, усан хангамж зэрэг салбаруудын НӨ улсдаа тэргүүлэх байр эзэлдэг, эсвэл хүн ам багатай улмаас амжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ өндөр гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна. Мөн энэ бүлгийн хүн ам зүйн ачаалал хамгийн их байгааг харгалзан үзвэл уг бүлэгт эдийн засгийн чадавхи сайтай аймгууд орсон болохыг харуулж байна.

**Бага бүлэг:** Өвөрхангай аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 8-рт, худалдааны НӨ-өөрөө 19-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 6-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 80 гаруй хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэрийг бусадтай харьцуулахад багагүй боловч Өвөрхангай аймаг хүн амын тоогоороо 2-рт (харьцангуй их) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага гарч байна.

Дорноговь аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 15-рт, худалдааны НӨ-өөрөө 5-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 11-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 80 гаруй хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэрийг бусадтай харьцуулахад бага ба Дорноговь аймаг хүн амын тоогоороо 17-рт (харьцангуй бага) орж байна. Улмаар уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага гарч байна.

Сэлэнгэ аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 6-рт, худалдааны НӨ-өөрөө 2-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 3-рт, боловсруулах үйлдвэрийн НӨ-өөрөө 3-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний дийлэнх хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн нийлбэрийг бусадтай харьцуулахад багагүй боловч Сэлэнгэ аймаг хүн амын тоогоороо 3-рт (харьцангуй их) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага гарч байна.

Төв аймаг Тус аймаг нь ХАА-н салбарын НӨ-өөрөө улсдаа 4-рт, худалдааны НӨ-өөрөө 3-рт, тээвэр холбооны салбарын нэмэгдэл өртгөөрөө 10-рт, боловсруулах үйлдвэрийн НӨ-өөрөө 4-рт орсон бөгөөд эдгээр салбарууд нь тус аймгийн ДНБ-ний 90-ээд хувийг бүрдүүлдэг юм. Хэдийгээр НӨ-үүдийн

нийлбэрийг бусадтай харьцуулахад багагүй боловч Төв аймаг хүн амын тоогоороо 6-рт (харьцангуй их) орж байгаагийн улмаас уг аймгийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага гарч байна.

Энэ бүлэгт орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг бусад бүлэгтэй харьцуулахад бага, хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь их байна. Мөн эдгээр аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, боловсруулах үйлдвэр зэрэг салбаруудын НӨ улсдаа доогуур байр эзэлдэг, эсвэл хүн ам ихтэйн улмаас амьжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ бага гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна. Хүн ам зүйн ачааллын хувьд авч үзвэл бусад бүлгүүдтэй харьцуулахад хамгийн бага байгаа хэдий ч үүний сайн нөлөө байхгүй байна.

**Дунд бүлэг:** Тус бүлгийн хувьд, түүнд орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг их (бага) бүлэгтэй харьцуулахад бага (их), хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь мөн саармаг байна. Энэ нь бүлэгт орсон аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, боловсруулах үйлдвэр зэрэг салбаруудын НӨ, хүн амыг бусадтай харьцуулахад улсдаа дундуур байр эзэлдэг, улмаар амьжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ-ийг бусадтай харьцуулахад саармаг (дунд) гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна.


К дундаж кластерийн шинжилгээ хийхэл ашиглагдсан үзүүлэлтүүдийг ашиглан к дундаж кластерийн алгоритмаас ялгаатай кластерийн шинжилгээний аргаар боловсруулалт хийсэн Кластерийн шинжилгээний өмнөх арга нь бие биенээсээ ялгаатай бүлгүүдэд хуваарилаж байсан бол энэ арга нь бие биетэйгээ адил төсөөтэй байдлаараа гинжин хэлбэрээр хуваарилагдаж байдгаараа ижил болон ялгаатай талуудтай байдаг. Хэдийгээр 2 өөр алгоритмаар гүйцэтгэсэн боловч үр дүнгүүд адил гарсан. Үр дүнг Зураг 7-д харуулав.

Зураг 7-оос харахад ерөнхийдөө гурвар бүлэг болгон үзэж болохоор байна.

Нэгдүгээр бүлэгт, Дорноговь, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай аймгууд; Хоёрдугаар бүлэгт, Сүхбаатар, Дархан-Уул, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь, Булган аймгууд; Гуравдугаар бүлэгт, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Архангай, Увс, Завхан, Ховд, Баян-Өлгий аймгууд орж байна.

Энд нэгдүгээр бүлгийн аймгууд өмнө хийсэн шинжилгээний бага бүлэгт, хоёрдугаар бүлгийн аймгууд их бүлэгт, гуравдугаар бүлгийн аймгууд дунд бүлэгт харьяалагдаж байна. Иймд үр дүн өмнөхтэй адил учраас тайлбар хийх шаардлагагүй юм. Судалж буй аймгуудыг эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр эрэмбэлэх зорилтыг тавьсан ба түүнийг шийдвэрлэх зорилгоор компонентийн шинжилгээг хийлээ. Учир нь кластерийн шинжилгээгээр гарган авсан үр дүнгээр судалгааны объектуудыг (сонгон авсан үзүүлэлтүүдээр) эрэмбэлэх боломжгүй юм. Иймд энэхүү судалгаандаа аймгуудыг эрэмбэлэхдээ нэгдүгээр гол компонентийн хувийн утгын тусламжтайгаар өмнөх үзүүлэлтүүдийг ашиглан гүйцэтгэсэн.

**Зураг 7. Дендрограмм**



**Хүснэгт 11. Компонентийн шинжилгээ , хувийн утга**

Параметр	Гол компонентууд		
	$f_1$	$f_2$	$f_3$
Хувийн утга - $\chi_v$	17.31798	0.50205	0.17996
Тухайн ( $v$ ) гол компонентийн нийт дисперс эзлэх хувь - $\frac{\lambda_v}{k} * 100 \%$	97.211	2.79167	0.009998
Эхний ( $m$ ) гол компонентийн нийт дисперс эзлэх хувь - $\sum_{v=1}^m \frac{\lambda_v}{k} * 100\%$	96.211	99.003	100.0

Хүснэгтээс харахад, нийт 18 гол компонентуудаас эхний 3 гол компонент анхны үзүүлэлтүүдийн нийт дисперсийн 100 хувийг (үүнээс нэгдүгээр гол компонент 97.2 хувийг ) бүрдүүлж байна. Тиймээс дээрх 3 гол компонентийг судлахад хангалттай. Фактор ачааллын матрицийг бичвэл:

**Хүснэгт 12. Компонентийн шинжилгээ , хувийн утга**

Аймгууд	$f_1$	$f_2$	$f_3$
1 Баян-Өлгий	0.99708	0.06493	-0.03197
2 Говь-Алтай	0.95976	0.22235	-0.17155
3 Завхан	0.98962	0.22235	0.04894
4 Увс	0.98970	0.22235	-0.01706
5 Ховд	0.99898	0.00188	-0.04511
6 Архангай	0.99503	0.02489	0.09645
7 Баянхонгор	0.92939	0.29204	-0.22570
8 Булган	0.99486	0.08008	0.06203
9 Өвөрхангай	0.99940	-0.01692	-0.02867
10 Хөвсгөл	0.99952	-0.01692	-0.02413
11 Дорноговь	0.86300	0.43311	0.26007
12 Өмнөговь	0.99939	-0.01914	0.02912
13 Сэлэнгэ	0.97998	-0.19268	0.05018
14 Төв	0.99815	-0.01122	-0.05969
15 Дархан-Уул	0.99614	0.07956	0.03719
16 Дорнод	0.97347	-0.22224	0.05436
17 Сүхбаатар	0.98288	-0.18317	0.01980
18 Хэнтий	0.99911	-0.04212	0.00125

Фактор ачааллын матрицийн элементүүд нь гол компонент болон аймгууд хоорондын хосын корреляцийн коэффициентийг харуулдаг тул аймгуудын нэгдүгээр гол компонентод харгалзах корреляцийн коэффициентийн хэмжээгээр нь эрэмбэлж болох юм. Энд нэгдүгээр гол компонент бүх аймгуудтай хүчтэй хамааралтай байна. Эрэмбэлсэн үр дүнг дараахь Хүснэгт 13-д харуулав.

Хүснэгтэнд үзүүлсэнчлэн Хөвсгөл аймаг нэгт орж байгаа бол Дорноговь аймаг хамгийн сүүлд буюу арван наймд жагссан байна. Аймгуудын тооцсон эрэмбүүдийг үндэслэн бүс нутгуудийн эрэмбийг тогтоовол нэгдүгээрт хангайн бүс, хоёрдугаарт төвийн бүс, гуравдугаарт баруун бүс, эцэст нь зүүн бүс орохоор байна.

### Хүснэгт 13. Аймгуудын рейтинг

Аймгууд	Эрэмбэ
1. Баян-Өлгий	7
2. Говь-Алтай	16
3. Завхан	12
4. Увс	11
5. Ховд	5
6. Архангай	9
7. Баянхонгор	17
8. Булган	10
9. Өвөрхангай	2
10. Хөвсгөл	1
11. Дорноговь	18
12. Өмнөговь	3
13. Сэлэнгэ	14
14. Төв	6
15. Дархан-Уул	8
16. Дорнод	15
17. Сүхбаатар	13
18. Хэнтий	4

### Дүгнэлт, санал

Манай улс аймаг, орон нутгийн хүн амын нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангах зорилгоор орчин үеийн дэлхийн нийтлэг жишиг, бусад орны туулсан замын дагуу "бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг баталж, "эдийн засгийн бүсчлэл"-ийг тогтоосон.

Зүүн, Баруун болон Төвийн бүс нутгуудын ажилгүйдлийн түвшний бууралт нь бодит буюу ажлын байр шинээр байгуулагдсантай холбоогүй, чанарын бус харин тоон өөрчлөлтийн үр дүн болсон.

Улаанбаатараас бусад бүсүүдийг харьцуулан үзэхэд Хангайн болон Төвийн бүсүүдэд эдийн засгийн салбаруудын нэмэгдэл өртгийн 70-95 хувийг үйлдвэрлэж байна.

Манай улсын ДНБ-ний 70 гаруй хувийг хөдөө аж ахуй, уул уурхай олборлох үйлдвэр, тээвэр агуулахын аж ахуй холбоо, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ салбарууд эзэлж байгаа бөгөөд манай орны эдийн засгийн хөгжил мал аж ахуй, бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээврийн салбарын хөгжлөөс хамаарч байна. Энэ нь Улаанбаатараас бусад аймаг, бүсийн түвшинд адил байна.

Бүх салбарын нэмэгдэл өртөгт (ХАА-н салбараас бусад) Улаанбаатарын бүс дийлэнх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд бусад бүсийн үндсэн салбар нь ХАА-н салбар болж байна.

Бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур байгаа нь бүс нутгуудын эдийн засгийн бүтэц оновчтой биш байгаад оршино. Гэвч сүүлийн 5 жилийн динамикаар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарын НӨ-ийн ДНБ-нд эзлэх хувийн жин аажмаар буурч, уул уурхай олборлох үйлдвэрийн салбар, жижиглэн, бөөний худалдааны салбар, тээврийн салбарын хувийн жин аажим өсч байгаа нь манай үйлдвэрлэлийн бүтцэд багахан өөрчлөлт орж байгааг илэрхийлж байна.

Аж үйлдвэрийн хөгжил бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Энэ нь манай улсын боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд бүс нутгуудын оруулж байгаа хувь нэмрээс тодорхой харагддаг. Тэдгээрийн эрэмбэлэхэд, Улаанбаатар, Төв, Хангайн, Зүүн, Баруун бүс орж байна.

Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээгээр үйлдвэрлэлийн цар хүрээг тодорхойлж болно гэсэн концепцийн үүднээс авч үзэн эдийн засгийн бүсүүдийг эрэмбэлбэл Улаанбаатар, Төв, Хангайн, Зүүн, Баруун гэсэн дараалалтай байна.

Хангайн болон Төвийн бүсүүд нь эдийн засгийн бүтэц, хөгжил, чадавхиараа ойролцоо болох нь судалгаанаас харагдаж байна. Гэвч Улаанбаатараас бусад салбаруудаас эдийн засгийн хөгжлөөрөө Хангайн бүс илүү байна. Үүнд, Орхон (уул уурхай, олборлох салбарын тэргүүлэгч аймаг) аймаг, ХАА-н салбарын үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч Хөвсгөл аймаг гол нөлөө үзүүлдэг байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд зааснаар бүсүүдийн тулгуур төвөөр Өвөрхангайн Хархорин, Орхон аймгийн Эрдэнэт, Төв аймгийн Зуунмод, Дархан-Уул аймгийн Дархан, Хэнтий аймгийн Өндөрхаан, Дорнодын Чойбалсан хотуудыг сонгосон нь тус бүсэд эдийн засгийн хувьд голлох үүрэг гүйцэтгэдэг аймгуудтай нийцэж байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт, бууралт нь тухайн бүсэд үйлдвэрлэгдсэн ДНБ-ний өөрчлөлтөөс шалгаалсан чанарын өөрчлөлтийн үр дүн юм. Эндээс үзвэл, бүсийн үйлдвэрлэл харьцангуйгаар нэмэгдэх хандлага буйг илэрхийлж байна.

Нэг хүнд ногдох ДНБ бага, аж үйлдвэржилтийн түвшин дорой байгаа Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ жилээс жилд эрчимтэй буурч байгаагийн шалтгаан болж байна.

Монгол Улсын төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн өнөөгийн байдлыг бүхэлд нь авч үзвэл бүс нутгуудаар өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Энэ нь тухайн бүсийн эдийн засгийн хөгжил, үйлдвэрлэлтэй шууд хамааралтай байна.

Тэнцвэртэй хөгжлийн хангах зорилгод нийцүүлэн аймгуудын ДНБ-ний нийт ДНБ-нд эзлэх хувийн жинг ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн хувийн жин болон аймгийн ДНБ-нд эзлэх төсвийн зарлагын хувийн жинг хамааруулан регресс тооцоход ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн хувийн жингээс илүү аймгийн ДНБ-нд эзлэх төсвийн зарлагын хувийн жин нөлөөтэй болох нь давхар батлагдсан. Энэ нь манай аймгуудын улмаар бүсүүдийн ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь өндөр байгаатай холбоотой бөгөөд аймгуудад үйлдвэрлэлээсээ илүү үйлчилгээний салбар ажиллаж байгаа зэргээс тухайн аймгийн ДНБ нь татаасаар санхүүжигдэн үйлдвэрлэгдэж байна гэж үзэж болно.

К дундаж кластерийн шинжилгээний үр дүнгээр гарсан Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Дорнод аймгуудаас бүрдсэн бүлгийн онцлог нь түүнд орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг бусад бүлэгтэй харьцуулахад өндөр, хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь бага байна. Энэ нь бүлэгт орсон аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, дулаан цахилгааны үйлдвэр, усан хангамж зэрэг салбаруудын НӨ улсдаа тэргүүлэх байр эзэлдэг, хүн ам багатай улмаас амьжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ өндөр гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна. Мөн энэ бүлгийн хүн ам зүйн ачаалал хамгийн их байгааг харгалзан үзвэл уг бүлэгт бусадтай харьцуулахад эдийн засгийн чадавхи сайтай аймгууд орсон болохыг харуулж байна.

Булган, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар, Дархан-Уул, Хэнтий аймгуудаас бүрдсэн бүлгийн онцлог нь түүнд орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг бусад бүлэгтэй харьцуулахад бага, хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь их байна. Энэ нь бүлэгт орсон аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, боловсруулах үйлдвэр зэрэг салбаруудын НӨ улсдаа доогуур байр эзэлдэг, хүн ам ихтэйн улмаас амьжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ бага гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна. Хүн ам зүйн ачаалалын хувьд авч үзвэл бусад бүлгүүдтэй харьцуулахад хамгийн бага байгаа хэдий ч үүний сайн нөлөө байхгүй байна.

Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгуудаас бүрдсэн бүлгийн хувьд, түүнд орсон аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ийг их (бага) бүлэгтэй харьцуулахад бага (их), хүн ам зүйн ачаалал болон ДНБ-нд эзлэх татаасын хувь мөн саармаг байна. Энэ нь бүлэгт орсон аймгуудын хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр холбоо, боловсруулах үйлдвэр зэрэг салбаруудын НӨ, хүн амыг бусадтай харьцуулахад улсдаа дундуур байр эзэлдэг, улмаар амьжиргааны түвшний үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ-ийг бусадтай харьцуулахад саармаг (дунд) гарахад хүргэж нэг бүлэгт орсон байна.

Кластерийн шинжилгээний өмнөх арга нь бие биенээсээ ялгаатай бүлгүүдэд хуваарилаж байсан бол энэ арга нь бие биетэйгээ адил төсөөтэй байдлаараа гинжин хэлбэрээр хуваарилагдаж байдагаараа ижил болон ялгаатай талуудтай байдаг. Хэдийгээр 2 өөр алгоритмаар гүйцэтгэсэн боловч үр дүнгүүд адил гарсан.

Аймгуудын тооцсон эрэмбүүдэд үндэслэн бүс нутгуудийн рангыг тогтоовол нэгдүгээр хангайн бүс, хоёрдугаарт төвийн бүс, гуравдугаарт баруун бүс, эцэст нь зүүн бүс орохоор байна.

Энэхүү судалгаанаас харахад Улаанбаатараас бусад бүх аймаг бүсүүдийн өнөөгийн эдийн засгийн байдал нь БХҮБ-ийн зорилгод хүрэхэд нэлээдгүй саад бэрхшээлтэй тулгарах нөхцөлтэй байна.

Бүсчлэлийн талаар гаргасан тогтоол, үзэл баримтлал бол энэхүү эдийн засгийн бүсчлэлийн эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа хэлбэр бөгөөд түүнийг хэрэгжүүлэх асуудлын хувьд тоон болон чанарын судалгаанд үндэслэн эдийн засаг, төсвийн зохистой бодлого явуулах шаардлагатай.

Эцэст нь тэмдэглэхэд, одоогийн засаг захиргааны хувиарлалтыг илүү үр ашигтай байхаар эргэн харж үзэх бодит шаардлага тулгарч байна. Ингэхдээ нийгэм, эдийн засгийн хувьд оновчтой, байгаль орчны хувьд тогтвортой, түүх соёлын хувьд иргэд хүлээн авахуйцаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх нь зүйтэй юм. Гэхдээ энэхүү өөрчлөлтийг хийхдээ дараахь тулгуур зарчмыг баримтлах нь чухал юм.

Үүнд:

- төрийн удирлага, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх;
- нийгмийн баялгийг бүтээхэд оролцох иргэдийн эрх боломжийг өргөжүүлэх;
- зүй ёсны төвлөрлийг бодлогоор зохицуулах;
- түүхэн уламжлал, орчин цагийн шаардлагад нийцүүлэн цогц байдлаар авч үзэх нь зүйтэй.



## Ном зүй

1. "Вопросы статистики" научно-информационный журнал 1/2005, Дубров А.М., Мхитарян В.С., Трошин Л.И., 1989. "
2. Г. Орсоо, 2002. "Үндэсний тооцооны данс, салбар хоорондын баланс" Улаанбаатар, Монгол
3. Jeffrey M.Wooldridge, 2003. "Introductory to Econometrics".
4. И.Л.Елисеева и другие, 2004. "Эконометрика"
5. Л.Цэдэндамба, О.Батхишиг, Х.Маам, 1999. "Монгол улсын өрнөд бүс". Улаанбаатар, Монгол
6. Монгол улсын Засгийн газар, Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, 2004. "Монголын хүний хөгжлийн илтгэл 2003".
7. Многомерные статистические методы".
8. М.Р.Ефимова, Е.В.Петрова, В.Н.Румянцев, 2001, "Общая теория статистики".
9. М.Г.Назарова и другие, 2000. "Курс социально-экономической статистики"
10. Н.М.Кремер, Б.А.Путко, 2003, "Эконометрика"
11. Үндэсний статистикийн газар, 2004. "Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2003 он". Улаанбаатар, Монгол
12. Үндэсний статистикийн газар, 2004. "Монгол Улс зах зээлд 1989-2002" статистикийн эмхэтгэл. Улаанбаатар, Монгол
13. Үндэсний статистикийн газар, 2003. "Монгол Улсын Хүний Хөгжлийн Илтгэл 2003 " нэмэлт тоо материал. Улаанбаатар, Монгол
14. Үндэсний статистикийн газар, 2004. "Статистик сэтгүүл". Улаанбаатар, Монгол
15. Үндэсний статистикийн газар, 2001. "2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн". Улаанбаатар, Монгол
16. Үндэсний статистикийн газар, 2002. "Улаанбаатар хотын тооллогын үр дүн" . Улаанбаатар, Монгол
17. Үндэсний статистикийн газар, 2002. "Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа". Улаанбаатар, Монгол
18. Үндэсний статистикийн газар, Дэлхийн банк, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр , 2004. "Өрхийн орлого, зарлага, амжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002-2003 он" Улаанбаатар, Монгол
19. Үндэсний статистикийн газар, Байгаль орчны яам, Азийн хөгжлийн банк, 2000. "Монгол орны байгаль орчны статистикийн эмхэтгэл". Улаанбаатар, Монгол
20. Хүн ам зүй сургалт судалгааны төв ,2001. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000". Улаанбаатар, Монгол
21. "Хөдөөгийн хөгжил ба жеңдэрийн асуудал " сэдэвт семинарын илтгэлүүдын эмхэтгэл 2002. Улаанбаатар, Монгол
22. "STATISTICA 6.0 " багц программын HELP
23. Т.Намжим, 2004. "Монгол Улсын эдийн засаг (эрт эдүгээ чинагш)". Улаанбаатар, Монгол
24. Төрийн мэдээлэл, 2001. "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" №28. Улаанбаатар, Монгол
25. Ф.А.Кузин, 1999. "Магистерская диссертация методика нависания, правило оформления и порядок защиты", Москва
26. Шинжлэх Ухааны Академи, Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2003. "Монгол улсын хөгжлийн судалгаа" №1. Улаанбаатар, Монгол